



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 06 сарын 21 өдөр

Дугаар А/184

Улаанбаатар хот

“Кайзен-2023” саналын системийн
хэрэгжүүлэх хөтөлбөрийг зохион байгуулах тухай

Харилцаа холбооны зохицуулах хорооны дүрмийн 3.1.2, 3.1.10 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Кайзен-2023” саналын системийг хэрэгжүүлэх хөтөлбөрийг 2023 оны 09 дүгээр сарын 18-ны өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 16-ны хооронд зохион байгуулсугай.
2. “Кайзен-2023” саналын системийг хэрэгжүүлэх хөтөлбөрийг зохион байгуулах удирдамжийг нэгдүгээр, бүтээмжийн багийн гишүүдийг хоёрдугаар, зардлын төсвийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Батлагдсан зардлын төсвийг холбогдох эх үүсвэрээс гаргахыг Санхүүгийн хэлтэс /Н.Халиунаа/-т зөвшөөрсүгэй.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газар /З.Эрдэнэчулуун/-т даалгасугай.

ДАРГА



Г.ЧИНЗОРИГ

“Кайзен саналын системийг хэрэгжүүлэх хөтөлбөр”

НЭГ. ЗОРИЛГО

1.1 Харилцаа холбооны зохицуулах хорооны хэмжээнд тасралтгүй сайжруулалтыг бий болгох зорилгоор ажилтнуудаас сайжруулалтын саналыг хүлээн авах, хэрэгжүүлэх, үнэлэн урамшуулахтай холбоотой харилцааг энэхүү журмаар зохицуулна.

ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ, НЭР ТОМЬЁО

1.2 Энэхүү журмын хариуцагч нь ХХЗХ-ны Захиргааны Хэлтэс байна.

1.3 Нэр томьёо:

Кайзен санал: Байгууллагын хөгжилд хувь нэмэр болох, богино хугацаанд, бага зардлаар байнгын тасралтгүй сайжруулалт хийх ажилтнуудын бүтээлч санал санаачилга,

Бүтээмжийн баг: Ажилтнуудын гаргасан кайзен саналын үр өгөөжтэй эсэхийг тодорхойлох, дэмжигдсэн саналыг хуваарилах, хэрэгжсэн кайзен саналыг үнэлэх, урамшуулахтай холбогдох үйл ажиллагааг зохион байгуулах үүрэг бүхий компанийн ажилтнуудаас бүрдэх баг

ГУРАВ. ҮНДСЭН ЗОХИЦУУЛАЛТ

3.1 Кайзен саналын системийн үйл ажиллагаа, хэрэгжилт, үнэлгээ хийх процесс

3.2. Процессийн тайлбар

3.2.1. Газар, хэлтэст тулгарч буй асуудлууд, сайжруулах шаардлагатай шинэ “Кайзен” саналыг хавсралт №1-д заасны дагуу Хүний нөөцийн мэргэжилтний албаны цахим хаягаар илгээнэ.

3.2.2. Ажилтнуудын гаргасан “Кайзен” саналыг Хүний нөөцийн мэргэжилтэн хүлээн авч, нэгтгэн 14 хоног тутамд Бүтээмжийн багт танилцуулан, ач холбогдлыг хэлэлцэн, шийдвэрлүүлнэ.

3.2.3. Бүтээмжийн баг ажилтнуудын саналыг хэлэлцэн, дэмжигдсэн, хэрэгжүүлэх боломжтой эсэхийг шийдвэрлэн, хэрэгжүүлэх ажлыг нэгжийн хэсэг, төслийн баг эсвэл ажилтанд хуваарилна.

3.2.4. Ажилтны гаргасан “Кайзен” саналыг дэмжигдсэн, дэмжигдээгүй эсэхийг ХН мэргэжилтэн ажилтанд албаны цахим хаягаар мэдээлнэ.

3.2.5. Санал ирүүлсэн ажилтнуудын урамшууллын мэдээллийг ХН мэргэжилтэн Санхүүгийн хэлтэст хүргүүлэн, урамшууллыг олгоно.

3.2.6. Бүтээмжийн багийн шийдвэрийн дагуу ХН мэргэжилтэн улирал бүр хэрэгжсэн саналууд, шилдэг саналуудын тайлан мэдээллийг дотоод мэдээллийн сувгуудаар ажилтнуудад мэдээллийг хүргэнэ.


ДӨРӨВ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛС

4.1 Кайзен саналд тавигдах шаардлага

4.1.1 Дараах агуулга бүхий саналыг хүлээж авна. Үүнд:

- Ажлыг хөнгөвчлөх, ажлын бүтээмж сайжруулах

Гурав: Кайзен саналын системийн үйл ажиллагаа, хэрэгжилт, үнэлгээ хийх процесс холболтод



- Үйл ажиллагаанд гарч буй зардлыг бууруулах
- Ажил гүйцэтгэх хугацааг багасгах
- Ажлын гарц, чанарыг сайжруулах. алдаа доголдлыг бууруулах
- Ажил гүйцэтгэх арга барилыг сайжруулах
- Ажлыг стандартжуулах
- Бүтээгдэхүүн, үйлчилгээг сайжруулах
- Хэрэглэгчийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх
- Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг сайжруулах

4.1.2 Дараах агуулга бүхий саналыг хүлээж авахгүй. Үүнд:

- Байгууллага газар, хэлтсийн зорилго, зорилт, үйл ажиллагааны зарчим, дотоод дүрэм журамтай зөрчилдсөн
- Бизнес төлөвлөгөө, удирдлагаас өгсөн үүрэг даалгавар, төслийн ажлын төлөвлөгөөнд тусгагдсан
- Хувийн чанартай гомдол, санал, шүүмж
- Хийсвэр санаа, баримт нотолгоогүй, биелэх боломжгүй санал
- Санал хэрэгжсэнээр хүлээгдэж буй бодит үр дүнгээс хэтэрсэн төсөв, зардал шаардагдах санал
- Батлагдсан саналын маягтын дагуу бүрэн мэдээлэл ирээгүй санал

4.2.Кайзен саналыг хэлэлцэх шалгуур үзүүлэлт

4.2.1.Ажилтны гаргасан кайзен санал зардал, цаг хугацаа, ажлын бүтээмж зэрэгт нөлөөлөх үү?

4.2.2.Ямар боломжит үр ашиг, үр дүн гарах вэ?

4.2.3.Хэрэгжих боломжтой санал мөн эсэх

4.3.Бүтээмжийн багийн бүтэц, үндсэн үүрэг

Бүтээмжийн багийн дарга: Захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газрын дарга

Бүтээмжийн багийн зохицуулагч: Хүний нөөцийн мэргэжилтэн

Багийн гишүүд:

Захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газрын төлөөлөл

Өргөн нэвтрүүлгийн зохицуулалтын газрын төлөөлөл

Радио давтамжийн зохицуулалт, хяналтын газрын төлөөлөл

Зах зээл, үнэ тарифын зохицуулалтын газрын төлөөлөл

Зохицуулалтын бодлогыг хэрэгжүүлэх газрын төлөөлөл

4.3.1.Бүтээмжийн багийн үндсэн үүрэг:

- Кайзен саналын системийн талаархи удирдамж боловсруулах, хэрэгжүүлэх
- Кайзен саналын сургалтыг компанийн нийт ажилтнуудад зохион байгуулах.
- Ажилтнуудыг кайзен саналын системтэй холбоотой мэдээллээр хангах.
- 14 хоног тутам хуралдаж кайзен саналуудыг үнэлэх, кайзен саналыг хэрэгжүүлэх багийг томилох, хэрэгжилтийг дэмжиж ажиллах
- Ажилтнуудын гаргасан кайзен санал, хэрэгжүүлсэн кайзен саналыг үнэлэх, урамшуулах
- Бүтээмжийн багийн гишүүн өөрчлөгдсөн тохиолдолд уг ажлыг хариуцсан дараагийн хүн багийн гишүүн болно.

4.4.Оролцогч талуудын үүрэг

4.4.1.Бүтээмжийн багийн даргын үндсэн үүрэг

- Бүтээмжийн багийг удирдан зохион байгуулж, гишүүдийн идэвхи оролцоог дэмжиж, багийн хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллах
 - Багийн гишүүд ажилтнуудаас ирсэн саналыг үнэлсэн байдал, хэрэгжүүлэх эсэх шийдвэр гаргалтуудад хяналт тавих
 - Кайзен саналын системийг идэвхжүүлэх, ажилтнуудад мэдээлэх ажлыг удирдан зохион байгуулах
 - Кайзен саналын системийг хэрэгжүүлэхтэй холбоотой компанийн дээд удирдлагын дэмжлэгийг авах
 - Багийн гишүүдийг үнэлж урамшуулах
- 4.4.2.Бүтээмжийн багийн зохицуулагчийн үүрэг
- Кайзен саналын системтэй холбоотой ажилтнуудыг идэвхжүүлэх, сургалт зохион байгуулах ажлыг гүйцэтгэх
 - Ажилтнуудын саналыг хүлээн авах, нэгтгэх бүтээмжийн багийн уулзалтыг тогтмол зохион байгуулах бэлтгэл ажлыг хийж гүйцэтгэх
 - Бүтээмжийн багийн уулзалтыг 14 хоног тутамд Пүрэв гаригийн 15:00 цагт зохион байгуулж байх
 - Кайзен саналын үнэлгээ, хэрэгжилтийн талаархи хариу мэдээллийг санал гаргасан ажилтанд өгөх
 - Кайзен саналын хэрэгжилтийн талаар тайлан бэлтгэх, танилцуулах
- 4.4.3.Багийн гишүүдийн үүрэг
- Өөрийн мэдлэг туршлага дээр үндэслэн ажилтнуудаас ирүүлсэн саналыг үнэлэх, тухайн сайжруулалттай холбоотой мэдээллийг бусад багийн гишүүдэд өгөх
 - Ажилтнуудаас ирсэн саналыг үнэлэх явцад тухайн саналыг нарийвчлан судлах, дэлгэрэнгүй тайлбар авах шаардлага гарвал холбогдох мэргэжилтнүүдтэй зөвлөлдөж мэдээлэл авах
 - Бүтээмжийн багийн гишүүд нь кайзен саналыг үнэлэх мэдлэг, чадвар бүхий дарга болон ахлах түвшний ажилтнууд байх
- 4.4.4.Кайзен саналыг хүлээн авсан газар, хэлтэс, хамт олны үүрэг
- Дэмжигдсэн кайзен саналыг газар, хэлтэс үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусган боломжит хугацаанд хэрэгжүүлэх
 - Кайзен саналын хэрэгжилтийн явцын мэдээллийг ХН мэргэжилтэнд өгөх
 - Тухайн кайзен саналыг хэрэгжүүлснээр ямар үр дүн гарсан талаар тухай бүр мэдээлэл өгөх

ТАВ. Кайзен саналыг шалгаруулах, урамшуулах

5.1.Кайзен саналыг ач холбогдол үр өгөөжөөс нь хамааран дараах байдлаар үнэлгээ хийнэ.

Үнэлгээний шалгуур	Үнэлгээний түвшин ба харгалзах оноо
--------------------	-------------------------------------

Сайжруулалтын үр дүн, ач холбогдол	Санал хэрэгжсэнээр маш өндөр үр дүн гарсан эсвэл үйл ажиллагаанд тулгамдаж буй байгууллагын томоохон асуудал, бэрхшээлийг шийдвэрлэсэн	Завсрын үнэлгээ	Хүлээгдэж буй үр дүн боломжийн түвшинд, тодорхой асуудал бэрхшээлийг бүрэн шийдвэрлэсэн	Завсрын үнэлгээ	Тодорхой үр дүн гарсан ба бага хүрээний асуудлыг шийдвэрлэсэн
	5 оноо	4 оноо	3 оноо	2 оноо	1 оноо
Саналыг хэрэгжүүлэхэд гаргасан хүчин чармайлт	Саналыг хамтын ажиллагаагаар хэрэгжүүлсэн, олон цагийн хөдөлмөр зарцуулсан	Завсрын үнэлгээ	Саналыг ажилтан олон цагийн хөдөлмөр гаргаж бие даан хэрэгжүүлсэн	Завсрын үнэлгээ	Саналыг ажилтан богино хугацаанд бие даан хэрэгжүүлсэн
	5 оноо	4 оноо	3 оноо	2 оноо	1 оноо
Саналын бүтээлч байдал	Санал нь бусад байгууллага практикт давтагдаагүй, онцгой бүтээлч санаа	Завсрын үнэлгээ	Санал нь өвөрмөц, онцгой ердийн нөхцөл байдалд бодож олохооргүй санаа	Завсрын үнэлгээ	Энгийн санаа
	5 оноо	4 оноо	3 оноо	2 оноо	1 оноо

5.2. Ажилтнуудын ирүүлсэн кайзен санал тутамд 5.000 төгрөгөөр урамшуулна.

5.3. Бүтээмжийн багаас гаргасан шийдвэрийн дагуу дэмжигдсэн саналд нэмэлтээр урамшуулал олгоно.

Сайжруулалтын саналын үнэлгээ	Тодорхойлолт	Урамшуулал
Дэмжигдээгүй кайзен санал	Байгууллагын бодитой асуудлыг шийдвэрлэхэд чиглээгүй эсвэл одоогийн нөхцөл байдалд хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага үүсээгүй эсвэл хүлээгдэж буй үр дүнгээс өндөр хэмжээний төсөв, зардал шаардагдах санал	Урамшуулалгүй
Дэмжигдсэн кайзен санал	Хэрэгжих боломжтой, байгууллагад гарч буй бодитой асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн, үйл ажиллагаанд бодитой үр өгөөж өгөх сайжруулалтыг илтгэсэн санал	20.000 төгрөг

5.4.Бүтээмжийн баг кайзен саналын хэрэгжүүлсний дараа доорхи шалгуурын дагуу ангилж кайзен санал гаргасан ажилтанд болон хэрэгжүүлсэн багт доорхи урамшуулал олгоно.

Кайзен саналын ангилал	Шалгуур	Хэрэгжүүлсэн багт урамшуулал олгох
Жижиг кайзен санал	Ажилтан богино хугацаанд бага хүчин чармайлтаар хийсэн жижиг сайжруулалт. Удирдлага болоод хамт олон олж хараагүй, жижиг өөрчлөлт хэдий ч бодитой үр өгөөж өгсөн сайжруулалт.	1 санал хэрэгжүүлэх багт 50.000
Дунд хэмжээний кайзен санал	Ажилтан тодорхой хүчин чармайлт гаргасан, нэмэлт мэдээлэл цуглуулсан, судалсан, шийдлийг гаргахад нарийн ухаан зарцуулсан, бодитой үр өгөөж өгсөн сайжруулалт.	1 санал хэрэгжүүлэх багт 100.000
Том сайжруулалт бүхий кайзен санал	Ажилтан бие даан болон багаар ажиллаж олон цагийн хөдөлмөр зарцуулсан, урт хугацаанд хэрэгжүүлсэн. Сайжруулалт нь алба болон хэлтсийн үйл ажиллагаанд тулгамдаж буй томоохон асуудлыг шийдвэрлэж чадсан.	1 санал хэрэгжүүлэх багт 150.000
Маш өндөр ач холбогдолтой кайзен санал	Ажилтан бие даан болон багаар ажиллаж олон цагийн хөдөлмөр зарцуулсан, урт хугацаанд хэрэгжүүлсэн. Сайжруулалт нь байгууллагад тулгамдаж буй томоохон асуудлыг шийдвэрлэсэн.	1 санал хэрэгжүүлэх багт 200.000

4.4.4.Шилдэг саналыг урамшуулах

- Шилдэг кайзен саналыг санал хэрэгжиж дуусах бүрд үнэлж, шилдэг эсэхийг шалгаруулах.
- Шилдэг кайзен саналаар шалгарах санал нь Үнэлгээний шалгуураас 14-15 оноо авсан байх.
- Шилдэг кайзен саналаар шалгарсан тохиолдолд ажилтан ганцаараа бие даан хэрэгжүүлсэн тохиолдолд 150,000 /ХАОАТ хасагдаагүй дүн/ төгрөг, багаар хэрэгжүүлсэн тохиолдолд 350,000 /ХАОАТ хасагдаагүй дүн/ төгрөгийн урамшуулал олгоно. /Шилдэг Кайзен санал нь 1-ээс дээшгүй байна/
- Байгууллагын үйл ажиллагаатай уялдуулан кайзен саналын сэдэвт уралдаан зарлагдах бөгөөд уралдааны удирдамжийн дагуу урамшууллыг тухай бүр шийдвэрлэн олгоно.
- Хэрэв Бүтээмжийн багийн гишүүдийн санал тэнцвэл Бүтээмжийн багийн дарга эцсийн шийдвэрийг гаргана.

ЗУРГАА. ГҮЙЦЭТГЭЛИЙН ХЭМЖҮҮР ҮЗҮҮЛЭЛТ

- 6.1.Нэг ажилтанд оногдох кайзан саналын тоо
- 6.2.Дэмжигдсэн саналын хувь
- 6.3.Хэрэгжүүлсэн саналын хувь
- 6.4.Ажилтнуудын оролцооны хувь

КАЙЗЕН САНАЛЫН ХУУДАС

Ажилтны нэр	Газар, хэлтэс	Илгээсэн огноо
Саналын нэр: (Юуг сайжруулах вэ)		
Саналын төрөл:		
<input type="checkbox"/> Зардал бууруулах <input type="checkbox"/> Бүтээмж дээшлүүлэх <input type="checkbox"/> Ажлын гарц, чанарыг сайжруулах <input type="checkbox"/> Ажлын арга барил сайжруулах <input type="checkbox"/> Ажлыг стандартжуулах	<input type="checkbox"/> Ажил гүйцэтгэх хугацааг багасгах <input type="checkbox"/> Шинэ бүтээгдэхүүн бий болгох <input type="checkbox"/> Хэрэглэгчийн үйлчилгээг сайжруулах <input type="checkbox"/> Бусад	
Одоогийн нөхцөл байдал/Гарч буй асуудлууд:		
<i>(Ямар асуудал гарч байгаа вэ, яагаад энэ асуудлыг шийдвэрлэх шаардлагатай вэ?)</i>		
Сайжруулах санал:		
<i>(Асуудал нөхцөл байдлыг хэрхэн сайжруулах вэ, сайжруулсны дараа ямар өөрчлөлт гарах вэ?)</i>		
Хэрэгжүүлэх арга зам:		
<i>(Сайжруулалтыг хийхэд ямар ажил хийгдэх вэ?)</i>		
Хүлээгдэж буй үр дүн, үр ашиг:		
<i>(Сайжруулалт хийснээр ямар үр дүн, нөлөөлөл гарах вэ)</i> 1. 2. 3. 4. 5.		

Харилцаа холбооны зохицуулах хорооны
Даргын 2023 оны 06 сарын 29 өдрийн
А/184 тоот тушаалын хоёрдугаар хавсралт

“Кайзен-2023” саналын системийн хэрэгжүүлэх
хөтөлбөрийн бүтээмжийн багийн гишүүд

Бүтээмжийн багийн дарга: Захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газрын
дарга

Бүтээмжийн багийн зохицуулагч: Хүний нөөцийн мэргэжилтэн

Бүтээмжийн багийн гишүүд:

Захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газрын, Хуулийн хэлтсийн
дарга Т.Ууганбат

Өргөн нэвтрүүлгийн зохицуулалтын газрын ахлах мэргэжилтэн П.Золбоо

Радио давтамжийн зохицуулалт, хяналтын газрын суурин хяналтын инженер
М.Болдбат

Зах зээл, үнэ тарифын зохицуулалтын газрын, Судалгаа шинжилгээний
хэлтсийн дарга Ч.Оюунгэрэл

Зохицуулалтын бодлогыг хэрэгжүүлэх газрын, Технологийн хөгжлийн төвийн
ахлах мэргэжилтэн Н.Цэнд-Аюуш